

МОНГОЛ АЛТАЙГААС ШИНЭЭР ИЛРҮҮЛСЭН ТЭРЭГНИЙ ДҮРСЛЭЛ

Ч.ЭНХТӨР¹, Ц.МӨНХБАТ²

¹Ховд аймгийн Манхан сумын Ахлах сургууль, e-mail: turguu@gmail.com

²Ховд аймгийн Манхан сумын Ахлах сургууль, e-mail: tsmunkhbat27@gmail.com

ТҮЛХҮҮР ҮГ: Ховд аймгийн Манхан сум, хадны зураг дээрх тэрэгний дүрслэл, мухлагт тэрэг, төмрийн түрүү үе, Хүннүгийн үе, хигээстэй ба хигээсгүй дугуй, хойд насны тухай ойлголт

ХУРААНГУЙ: Бид энэхүү өгүүллээр Манхан сумын нутагт шинээр илрүүлсэн хадны зурган дахь дөрвөн тэрэгний дүрслэлийг танилцуулан тэдгээрийн он цаг, дүр дүрслэлийн талаар өөрсдийн саналыг толилуулж байна. Өгүүлэн буй тэрэгний дүрслэлүүд нь Монгол орны бусад нутгаас илрээд буй тэрэгний дүрслэлүүдээс зарим нэг талаараа ялгаатай. Бидний өгүүлэх тэрэгний дүрслэлүүдэд үхэр, адууг хөллөсөн байх ба үхэр хөллөсөн тэргийг мухлагтай өвөрмөц байдлаар дүрсэлжээ. Монгол болон хил залгаа бүс нутагт байх тэрэгний дүрслэлүүдтэй харьцуулсны дүнд Манхан сумын Баянтүмбэ, Хавтгайн хамрын үзүүрээс илэрсэн 2 тэрэгний он цагийг төмрийн түрүү үед, харин Хүрэн дэлийн нуруунаас олдсон 2 тэргийг Хүннү гүрний үед холбогдуулж үзэх саналтай байна. Түүнчлэн, хадны зурагт тэрэгний дугуйг хигээстэй дүрсэлсэн нь нүүдэлчдийн өдөр тутмын ахуй амьдралдаа өргөн хэрэглэдэг тэрэг гэсэн утга илэрхийлж байгаа бол харин буган хөшөөн дээрх хигээсгүй тэрэг нь, магадгүй, талийгаачийн хойд насны ойлголттой холбоотой байж болох юм гэсэн урьдчилсан дүгнэлтийг хийж байна.

Ch. ENKHTUR, Ts. MUNKHBAT

NEWLY DISCOVERED CHARIOT IMAGES FROM THE MONGOLIAN ALTAI

KEYWORDS: Mankhan soum Khovd aimag, chariot image in the petroglyph, chariot, Early Iron Age, Xiongnu period, wheels with spokes, symbolic meaning related to the afterlife of the deceased.

ABSTRACT. In this article, we introduce images of four chariots newly discovered in the rock paintings in Mankhan soum, Khovd aimag and present our views on their dates and descriptions. Comparing the images of chariots found in Mongolia and the contiguous areas, it is suggested that the two chariot images found at Bayantumbe and Khavtgai Khamryn uzuur sites, Mankhan soum date back to the Early Iron Age, while the other two chariots found in the Khuren Del Mountain range date back to the Hunnu period. In addition, we propose, that the chariots in the petroglyphs depicted with wheels and spokes may mean its wide use in daily lives of nomads, while the non-spoke wheel chariots on the deer stones may have symbolic meaning related to the afterlife of the deceased.

ТЭРЭГНИЙ ДҮРСЛЭЛИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

Монгол орны нутгаас олноор буй хүрлийн үеийн хадны зургийн сэдэвт тухайн үеийн хүмүүсийн аж байдал, шүтлэг, ан агнуур, зэр зэвсэг, араатан амьтан, янгир, буга, адуу, тэмээ зэрэг амьтдаас гадна хүний нүүрний баг, адуу, тэмээ, үхэр хөллөсөн тэрэгний дүрслэл зохих байр суурийг эзэлдэг. Дээрх хадны зургийн дүрслэлүүд дотроос тэрэгний дүрслэл Алтай, Хангайн нурууны хадны зурагт элбэг байх боловч Хэнтий, Хөвсгөлийн уулсаар цөөн тохиолддог байна (Анхсанаа 2017: 83). Монгол орны нутагт хадны зургийн дурсгал шинээр илрэх бүрт үүнийг дагаж тэрэгний дүрслэлийн тоо нэмэгдсээр байгаа юм. 1990-ээд оны дунд үед хадны зургаар дагнан гарсан судалгааны бүтээлд Монгол орны нутгаас 200 гаруй тэрэгний дүрслэл илэрснийг дурьдсан байдаг (Санжмятав 1995: 78) бол өдгөө албан бус тоогоор 400 гаруй илрээд байгааг судлаачид тэмдэглэсэн (Анхсанаа 2017: 83).

Сүүлийн жилүүдэд олон тоогоор шинээр олдсон тэрэгний дүрслэлүүд ихэвчлэн Баян-Өлгий аймгийн нутагт орших Монгол Алтайн уулсын хөндийгөөс илрээд байна. Тухайлбал, Монгол-Орос-Америкийн хамтарсан шинжилгээний анги Монгол Алтайд Цагаан салаа, Бага Ойгороос 30 орчим (Jacobson et al., 2001), Шивээт хайрханаас 60 гаруй (Цэвээндорж нар, 2010: 72), Цэнгэл сумын Далан Түргэний хос толгойгоос 26 тэрэгний зураг (Цэрэндагва, Цэвээндорж 2016) илрүүлжээ. Судлаач Б.Өмирбек Баян-Өлгий аймгийн Буянт сумын нутаг Хойд Хөлцөөтөөс 9 тэрэгний зураг илрүүлсэн бөгөөд тэрээр мөн аймгийн нутгаас 170 гаруй тэрэгний дүрслэл олноор буйг дурджээ (Өмирбек 2012: 91-100). Судлаач Б.Даваацэрэн Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутаг Таван толгойн баруун булангийн хадны зургаас тэрэгний зураг шинээр олж илрүүлэн нийтлүүлсэн байна (Даваацэрэн 2013: 37). Доктор Н.Батболд Говийн бүсийн хадны зургаас тэрэг, түүнтэй холбоотой дүрслэл 14 илрүүлсний 10 нь хоёр дугуйтай, нэг нь дөрвөн дугуйтай, гурван зурагт тэрэгний дугуй, эд ангийг салангид дүрсэлснийг тэрэг хийж буйг үзүүлэхийг хичээсэн хэмээн үзжээ. Ихэнх тэрэгний дугуй 4-8 хигээстэй, хоёр тэрэгний дугуйг хигээсгүй, голдоо нүхтэй цул байдлаар дүрсэлжээ. Мөн дөрвөн морь хөллөдөг тэрэг хоёр байгаагийн нэг нь морьд хөллөсөн, дөрвөн дугуйтай, харин нөгөөд нь хөллөөгүй, бүтэц, зохион байгуулалтыг нь мэдэж болохоор хоёр дугуйтайгаар дүрсэлсэн гэжээ (Батболд 2014: 87). Судлаач Г.Анхсанаа Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Цагаан усны гол хэмээх газраас тэмээ хөллөсөн өвөрмөц дүрслэлтэй тэрэгний зургийг илрүүлж нийтлүүлсэн байна. Цагаан усны голын хадны зурагт тэргийг дүрслэхдээ нэг дугуйг 6, нөгөөг нь 8 хигээстэй дүрслээд хооронд нь нэлээн урт нарийн тэнхлэгээр холбож, хос гуя (арал) зэргийг дэлгэмэл байдлаар харуулж дүрсэлсэн ба тэргийг хажуу талаас нь харуулахыг эртний зураачид хичээсэн бололтой хэмээжээ (Анхсанаа 2017: 83). 2010 онд Ховд их сургуулийн багш доктор Ч.Мөнхбаяр, магистрант Б.Мөнхбаатар нар Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан уулнаас дүрслэл, зохиомжийн хувьд сонирхолтой олон тооны зургийг илрүүлэх явцдаа хос морь хөллөсөн тэрэгний дүрслэлийг илрүүлж өгүүлэл болгон хэвлүүлжээ (Мөнхбаяр, Мөнхбаатар 2010: 218-248).

Тэрэгний дүрслэл нь хадны зургаас гадна одоогоор хоёр буган хөшөөнд дүрслэгдсэн тохиолдол илрээд байна. Дээрх хоёр буган хөшөө нь баруун бүс нутагт

оршиж байгаа нь ихээхэн сонирхолтой цаашид лавшруулан судлах шаардлагатай асуудал юм. В.В.Волков (2002) Ховд аймгийн Дарви сумын нутаг Чулуутын огтрог хэмээх газраас хос морь хөллөсөн хигээсгүй тэрэгний дүрслэлийг олж илрүүлсэн байдаг бол Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг Бүлцэн уулын ойролцоо орших буган хөшөөнд 4 морь хөллөсөн хигээсгүй морин тэрэгний дүрслэлийг олж илрүүлсэн (Нямбат, Одбаатар 2010: 59).


Бид сүүлийн жилүүдэд явуулсан багахан хэмжээний хайгуул судалгааны явцад Ховд аймгийн Манхан сумын Улаан хүрээ багийн Хүрэн дэлийн нуруунаас 2, Ботгон багийн Хавтгайн хамрын үзүүрээс 1, Баянтүмбэ уулнаас 1, нийт 4 тэрэгний зургийг шинээр илрүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж дээрх тэрэгнүүдийн холбогдох он цагийг тодорхойлохын сацуу тэрэг хүрлийн үеэс аж ахуйд хэрэглэгдэхээс гадна хойт насны ойлголттой хэрхэн холбогдож болохыг тодруулахыг зорилоо.

Хүрэн дэлийн нуруунаас олдсон тэрэгний дүрслэлүүд. Ховд аймгийн Манхан сумын төвөөс баруун хойт зүгт 18 км-ийн зайд Улаан-Хүрээ багийн нутагт сунаж тогтсон хүрэн уулсыг нутгийнхан Хүрэн дэл хэмээн нэрлэдэг. Хүрэн дэл гэж нэрлэсний учир нь уг уулны өнгө нь хүрэн байхаас гадна морины дэл шиг сунаж тогтсон тул ийн нэрлэсэн бололтой. Тус ууланд дүрслэл, зохиомжийн хувьд ихээхэн өвөрмөц 1000 гаруй зураг бий. Энэхүү уулнаас тэрэгний хоёр дүрслэлийг шинээр илрүүллээ.


1-р тэрэг. Мухлагт тэргэнд солжир эвэртэй үхрийг хөллөсөн дүрслэл. Уг хадны зурагт үхэр болон мухлагт тэргийг нилээд тод, уран гоёмсог, нарийн хийцтэйгээр дүрсэлжээ. Үхрийг бүх биеэр нь дүрслээд нуруу сэрвээ хэсэгт нь тэрэгний арал (буулга)-ыг бэхэлж өгснийг тод харуулжээ. Үхрийн урд хоёр хөлийг эгц шулуун байдлаар, харин хойд хоёр хөлийг нугалсан байдалтай урласан. Тэргийг дугуйгүй битүү мухлагтайгаар дүрсэлсэн (Зураг 1).

2-р тэрэг. Хүрэн дэлийн нуруунд Монгол орны нутгаас илрээд буй тэрэгнүүдээс дүрслэлээрээ арай өөр нэгэн тэрэг бий. Учир нь монгол орны нутгаас илрээд буй тэрэгний зургуудад ганц дугуйтай тэрэгний дүрслэл ховор байдаг. Уг тэрэг нь ганц цулгуй бөөрөнхий дугуйтай, дээр нь бүхээг гэж хэлж болохоор дөрвөлжин зүйлийг сийлсэн, үүн дээр хоёр бариултай гэмээр тэргийг үл танигдах нэгэн амьтан чирч буйгаар дүрсэлжээ. Уг амьтныг хоёр хөлтэй дүрслээд хөлийг нь урагш алхаж буйгаар сийлжээ (Зураг 2). Хүрэн дэлийн нуруунаас олдсон хоёр тэргийг эртний зураачид хажуу талаас нь харсан байдлаар дүрсэлсэн байна.

Хавтгайн хамрын үзүүрийн тэрэгний дүрслэл. Ховд аймгийн Манхан сумын төвөөс баруун зүгт 40 км-ийн зайд Ботгон багийн нутаг Хавтгайн хамрын үзүүрт өвөрмөц дүрслэлтэй нэгэн тэрэгний зураг бий. Энэхүү тэргийг хоёр дугуйтай, зургаан хигээстэй нэг аралтайгаар дүрсэлсэн. Уг тэргийг ямар амьтанд хөллөсөн нь сайн мэдэгдэхгүй бөгөөд тэрэгний ард талд бөөрөнхий зүйлийг урлажээ. Тэрэгний хажуу талд дүрслэл сайтай морины зураг байгаа нь магадгүй уг тэргэнд морь хөллөдөг байсан бололтой (Зураг 3). Өгүүлэн буй зурагт тэргийг дээрээс нь харсан байдалтай сийлсэн.





Зураг 1. Хүрэн дэлийн нурууны хадны зураг дахь мухлагт тэрэгний дүрслэл



Зураг 2. Хүрэн дэлийн нурууны хадны зураг дахь 2-р тэрэгний дүрслэл



Зураг 3. Хавтгайн хамрын үзүүрийн хадны зураг дахь тэрэгний дүрслэл



Зураг 4. Баянтүмбэ уулын хадны зураг дахь тэрэгний дүрслэл

Баянтүмбэ уулнаас олдсон тэрэгний дүрслэл. Ховд аймгийн Манхан сумын төвөөс өмнө зүгт 5 орчим км-ийн зайд Баянтүмбэ хэмээх уул бий. Уг ууланд нэгэн тэрэгний дүрслэл байдаг. Тэргийг хос дугуйтай, нэг дугуйг нь 4 хигээстэй, нөгөө дугуйг нь цулгуйгаар дүрсэлсэн. Тэрэгний арлыг нэлээд уртаар дүрслээд хос морь хөллөсөн байдалтай урлажээ. Хоёр дугуйны холбоос гол дээр гараа унжуулан зогсож буй хүнийг дүрсэлсэн (Зураг 4).

ТЭРЭГНИЙ БЭЛЭГДЭЛ

Эртний хүмүүсийн бүтээсэн, ахуй амьдралд нь чухал ач холбогдолтой, одоогийн автомашинтай дүйцэхүйц чухал зүйл нь тэрэг юм. Тэргийг бүтээснээр эртний хүмүүсийн ахуй амьдралд асар их өөрчлөлт гараад зогсохгүй хөдөлмөрийн бүтээмж үлэмж нэмэгдсэн нь ойлгомжтой. Тэргийг Орос, Украйнууд “тэрэг” гэдгийг жаахан хазгай буюу *p* авиаг л болгон *телега* (*телига*), харин түрэг нар *талика*, татарууд *тэгдрмаг*, алтайчууд *тэхэрэг* гэцгээдэг байжээ (Өмирбек 2012: 105). Хүрлийн үеийн ард түмэн тэргийг ахуй амьдралдаа хэрэглэхээс гадна ертөнцийг үзэх үзэл, хойт насны ойлголттой холбон үзэж буган хөшөөнөө сийлдэг байсан бололтой. Хадны зурагт байх тэрэгний дүрслэл нь ихэвчлэн хигээстэй байхад буган хөшөөнд байх тэрэгнүүд хигээсгүй байгаа нь ихээхэн сонирхолтой. Одоогоор Монгол орны нутгаас хигээсгүй тэрэг дүрсэлсэн буган хөшөө хоёр олдод байгаа нь Ховд аймгийн Дарви сумын Чулуутын огтрог (Зураг 5), Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг Бүлцэн уулын (Зураг 6) ойролцоо орших буган хөшөөд юм (Нямбат, Одбаатар 2010: 59).

Төв Азид эрт үед амьдран сууж байсан хадны зураг, буган хөшөө бүтээгчдийн ертөнцийг үзэх үзэлд тэргийг дүрслэхтэй холбоотой салаа үзэл байсныг үгүйсгэх аргагүй юм. Сүүлийн зуу гаруй жилийн судалгаа шинжилгээгээр буган хөшөөг овог аймгийн баатарлаг дайчин удирдагч нарт зориулан босгосон дурсгал юм гэдгийг судлаачид санал нэгтгэйгээр дэмжээд байгаа (Баярсайхан 2016). Тэргийг хаданд дүрслэхдээ морь, үхэр, тэмээ гэх мэт амьтанд хөллөсөн байдлаар дүрсэлсэн байдаг бол буган хөшөөнд тэрэгний дүрслэлүүдийг ихэвчлэн морь хөллөсөн байдлаар сийлсэн. Монгол орны төвийн бүс нутагт орших буган хөшөөний дэргэд маш олон тооны адууны толгойгоор тайлга тахилгыг үйлдсэн байдаг нь санамсаргүй зүйл биш бөгөөд буган хөшөөнд адуу дүрсэлсэн тохиолдол олон бий (Баярсайхан 2016). Тэгэхээр хүрлийн сүүл төмрийн түрүү үеийн нүүдэлчдийн амьдрал ахуй, дайн тулаан, уналга эдэлгээнд адуу чухал үүрэгтэй байсан төдийгүй тэдний ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэлд адуу томоохон байр суурь эзэлдэг байсныг дээрх олдвор гэрчилж байна.

Эртний тэрэг зураачид магадгүй, баатарлаг удирдагч дээдсийнхээ сүнсийг дээд тэнгэрт хүргэх унаа хэмээх ойлголтоор буган хөшөөнд дээр адуу хөллөсөн хигээсгүй, явах боломжгүй тэргийг билэгдлийн шинжээр урласан байх боломжтой юм. Харин хадны зурагт дүрслээд буй морь, үхэр, тэмээ хөллөсөн хигээстэй тэрэгнүүд нь эртний нүүдэлчдийн өдөр тутмын амьдрал ахуйдаа өргөн хэрэглэдэг тэрэг бололтой. Бидний дэвшүүлж буй саналтай холбоотой байж болохоор баримт хүннү, эзэнт гүрний үеийн түүхэнд ажиглагдаж байгаа нь ихээхэн сонирхолтой юм.

Хүннүгийн язгууртны булш бунханд дагалдуулан тавьдаг эдийн соёлын томоохон төлөөллийн нэг бол хүннү нарын хэрэглэж байсан морин тэрэг буюу мухлаг тэрэгнүүд юм. Өнөө хүртэл малтан шинжилсэн Хүннүгийн язгууртны булшны малтлага

судалгаанаас тэрэгний эд анги, тэрэгтэй холбоотой зүйлс түгээмэл олдсоор байна (Эрдэнэбаатар нар 2015: 94). Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг Балгасын талын Гол мод-2-ын 1-р булш буюу Хүннүгийн хааны булшны бунхны дээд, гадна талд, тухайлбал, бунхныг дарж булсан нэг үе, чулуун дараас, түүний дээрх гал түлж ариусгасан нүүрсэн үе дээр 15-16 сүйх тэргийг зориудаар эвдэж, тавьсан байна (Мөн тэнд). Төв аймгийн Ноён уулын хүннүгийн язгууртны 1, 6, 25-р булш (Руденко, 1962), Хүнүй голын хөндий дэх Гол мод 1-д малтан шинжилсэн язгууртны 1-р болон 20-р булш (Ерөөл-Эрдэнэ, Гантулга 2007: 258-279), Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Дуурлиг нарсанд малтан судалсан хүннүгийн язгууртны 2-р булш (Цэвээндорж 2011: 58-91), Ховд аймгийн Манхан сумын Тахилтын хотгорын язгууртны 1-р булш (Наваан 1999), ОХУ-ын Царамын 7-р булш (Эрдэнэбаатар 2015: 97) зэргээс тэрэгний эд анги, гоёл чимэглэлийн зүйлс ихээр олдсон байна. Хүннүгийн язгууртны булшинд тэрэгний эд анги, чимэглэлийн зүйлс дагалдуулсан нь булшны эзний язгуур угсаа, нийгэмд эзлэх байр суурийг илтгэхээс гадна хойд насанд нь хүргэж өгөх унаа болдог ёс байсан болохыг үгүйсгэх аргагүй хэмээн зарим судлаачид өөрсдийн бүтээлдээ тэмдэглэжээ (Мөн тэнд).

XIII зууны үеийн монголчуудын дунд тэргийг хойд настай холбож үзэх ойлголт байсан бололтой. Монголын нууц товчоонд эзний алтан хүүрийг хасаг тэргэнд тээж харин өөд болон ирэхэд Сөнөдийн Гилүгэтэй баатар магтан шүлэглэсэн нь:

«Хамгийн хаан, улсын эзэн минь

Харцгай шувууны жигүүр болон одов.

Хангинах тэрэгний тээш болон одов.

Жиргэх шувууны жигүүр болон одов.

Жигдрэх тэрэгний ачаа болон одов» гэж магтан дуулсан байдаг (Паламдорж, Мягмарсамбуу 2006: 135). Дээрх шүлгийг ажиглахад талийгаачтай тэрэг ямар нэгэн холбоотой нь илт мэдэгдэх бөгөөд Гилүгэтэй баатар хааны алтан хүүрийг ачсан хасаг тэргийг хараад шууд утгаар шүлгэндээ тэрэгний тухай бичсэн үү? эсвэл XIII зууны Монголчуудын ертөнцийг үзэх үзэлд тэрэг нь талийгаачийн сүнсийг нөгөө ертөнцөд хүргэх унаа гэсэн ойлголтоор шүлэглэсэн үү? гэсэн салаа санал гарч байна. Хүрлийн үеэс их монгол улсын үе хүртэл олон мянган жилийн турш монгол нутагт оршин байсан нүүдэлчдийн дунд бөө мөргөл голлож сүсэг бишрэлийн ойлголт нэг их өөрчлөгдөөгүй ирсэн гэж үзэж байгаа тул бидний зүгээс сүүлийн саналыг дэмжиж байна. Буган хөшөөнд хигээсгүй тэрэг сийлэгдсэн явдал, Хүннү нарын хаад язгууртнуудаа оршуулахдаа олон тэрэг дагалдуулах ёс, XIII зууны үед хааны алтан хүүрийг тээж ирсэн магтаал зэргийг ажиглахад эртний монголчуудын хойд насны ойлголтонд тэрэг онцгой байр суурьтай бөгөөд хаад язгууртнуудын сүнсийг нөгөө ертөнцөд хүргэдэг унаа гэсэн ойлголтоор ихээхэн билэгшээн шүтэж буган хөшөөнөө сийлж, магтаал шүлгэндээ оруулдаг байсан бололтой.

ТЭРЭГНИЙ ОН ЦАГ


Монгол нутагт илэрч олдсон хадны зурагт дүрслэгдсэн нийт тэрэгний он цагийн талаар судлаачид ерөнхийд нь хүрлийн үед холбогдуулан үздэг боловч цөөн хэдэн тэрэгний он цагийг хүннү гүрний үед хамааруулдаг. Хүрлийн үед холбогдох боломжтой тэрэгнүүдээс хамгийн эрт үед холбогдохыг археологич Д.Цэвээндорж НТӨ III-II мянган

жилд (Цэвээндорж 1999: 75), Д.Дорж НТӨ III-I мянган буюу хөгжингүй хүрлийн үед (Дорж 1969: 42), П.М.Кожин (Кожин 1968: 36), В.В.Волков (Волков 1972: 87), Д.Наваан (Наваан 1976: 213), Э.А.Новгородова (Новгородова 1984: 78), Т.Санжмятав (Санжмятав 1995: 71) нарын судлаачид тэднээс арай хожуу НТӨ II-I мянганд, Ц.Доржсүрэн (Доржсүрэн 1961: 25), А.П.Окладников (Окладников 1964: 210) нар НТӨ VII-IV зуун буюу Скифийн үед холбогдуулах санал дэвшүүлжээ. Бид Манхан сумын Ботгон багийн Хавтгайн хамрын үзүүр, Баянтүмбэ уулнаас шинээр илэрсэн тэрэгнүүдийг НТӨ III-I мянган жилд холбогдуулан үзэх саналтай байна. Учир нь дээрх тэрэгний зургуудтай ижил дүрслэлтэй тэрэг Архангай аймгийн Чулуутын гол (Санжмятав 1995: 54), Баян-Өлгийн аймгийн Цагаан салаа, Бага Ойгор (Цэрэндагва 2016: 32, Зураг 12), Шивээт хайрхан (Цэвээндорж нар 2010: 61) зэрэг газруудад дүрслэгдсэн тэрэгний зургуудтай тун ижил байна.


Хүннүгийн үед холбогдох тэрэгний талаархи хэрэглэгдэхүүн гэвэл:

1. Булш, оршуулгаас гарсан биет олдворууд
2. Хадны зураг болон зарим үйсэн эдлэл дээрх тэрэгний дүрслэлүүд юм.

Хүннүгийн үеийн сүйх тэргийг хийц, бүтцийн хувьд: 1. Шүхэрт тэрэг, 2. Мухлагт тэрэг гэж ангилж, харин мухлагт тэргийг хэлбэрээр нь: а. Нуман оройтой, тэгш өнцөгт хэлбэрийн мухлагтай, б. Бөмбөгөр оройтой дөрвөлжин мухлагтай хэмээн ангилж болохоор байна. Монголын нутгаас олдсон мухлагт тэрэгний дүрслэлүүд гэвэл Ховд аймгийн Үенч сумын нутаг Ямаан усны хадны зураг дахь (Зураг 7) 1-3 морь хөллөсөн мухлагт тэрэг (Волков 1972: стр. 75-89, рис. 5,6), Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уулын Баруун Овоот Өндөрийн ар шилийн хадан дахь үхэр хөллөсөн мухлаг тэрэг (Зураг 8) (Баттулга 1998: 109-115, зур. 7), Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын Бурхан толгойн 79-р булш (Төрбат 2001: 66-68) (Зураг 9), ОХУ-ын Буриадын Царамын 7-р булш (Миняев, Сахаровская 2006: стр 197-198) -наас гарсан үйсэн эдлэл дээрх хөллөгөөнд ороогүй мухлагт тэрэг (Зураг 10) зэрэг болно.



Зураг 5. Ховд аймаг Дарви сумын Чулуутын огтрогийн буган хөшөөний тэрэгний дүрслэл



Зураг 6. Увс аймаг Зүүнхангай сумын Булцэн уулын буган хөшөөний тэрэгний дүрслэл



Зураг 14. Ховд аймаг Алтай сум Ямаан усны хадны зураг



Зураг 8. Дундговь аймаг Өлзийт сум Дэл уулын хадны зураг



Зураг 9. Бурхан толгойн 79-р булшнаас олдсон үйсэн эдлэл дээрх дүрслэл



Зураг 10. ОХУ-ын Буриадын Царамын 7-р булшнаас олдсон үйсэн эдлэл дээрх дүрслэл

Хүрэн дэлийн нуруунаас олдсон 1-р тэрэг нь мухлагт тэрэгний ангилалд багтах бөгөөд Дэл уул, Эгийн голын Бурхан толгойн 79-р булш, ОХУ-ын Буриадын Царамын 7-р булшнаас гарсан үйсэн дээрх мухлагт тэрэгний дүрслэлтэй ижил байна. Хүрэн дэлийн нурууны 2-р тэрэг нь мөн дээрх тэрэгтэй нэлээд төстэй, иймд дээрх хоёр тэрэгний хэрэглэгдэхүүнийг бид хүннү гүрний үед холбогдуулан үзэх саналтай байна. Манхан сумын Хүрэн дэлийн нурууны хадны зураг нь Тахилтын хотгорын хүннү булшны цогцолбортой маш ойр бөгөөд энэ бүс нутаг нь хүннү гүрний баруун захын хязгаар нутаг байсан. Тахилтын хотгорын хүннүгийн язгууртны булшнаас тэрэгтэй холбоотой олдвор нэлээд гарсан (Наваан 1999), мөн бидний өгүүлэн буй тэрэг нь дүрслэлийн хувьд хүннүгийн үед холбогдох бүрэн боломжтой байгаа нь хүннүгийн баруун хязгаарт тэргийг өргөн хэрэглэж байсны илрэл юм.

ДҮГНЭЛТ

Ховд аймгийн Манхан сумын нутаг түүх соёлын дурсгалаар баялаг бөгөөд хуучин чулуун зэвсгийн үеэс орчин үеийг хүртэлх бүх үед холбогдох археологийн биет дурсгал арвин олддог. Монголын төдийгүй дорно дахины ард түмний урлагийн түүхийн эхлэл болсон Гурван Сэнхэрийн агуй, хаад язгууртнуудаа онголсон Тахилтын хотгорын хүннү булшны цогцолбор, Алтайн Түрэгүүдийн хэрэглэж байсан Алтай ятга зэрэг хүн төрөлхтөний түүхийн хосгүй дурсгалууд энэ нутгаас олдсон юм. Бид энэ бүс нутагт сүүлийн жилүүдэд явуулсан багахан хайгуул судалгааны явцад олон сонирхолтой дурсгалуудыг илрүүлсний нэг нь хадны зурагт байх тэрэгний дүрслэл юм. Энэхүү өгүүллээр Ховд аймгийн Манхан сумын нутгаас шинээр илрүүлсэн 4 тэрэгний хэрэглэгдэхүүнийг эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулж байна.

Өгүүлэн буй 4 тэрэгний он цагийг Монгол болон хил залгаа бүс нутагт байх тэрэгний дүрслэлүүдтэй харьцуулсны дүнд Манхан сумын Баянтүмбэ, Хавтгайн хамрын үзүүрээс илэрсэн 2 тэрэгний он цагийг төмрийн түрүү үед, харин Хүрэн дэлийн нуруунаас олдсон 2 тэргийг Хүннү гүрний үед холбогдуулж үзэх саналтай байна. Учир нь Хүрэн дэлийн нуруунаас олдсон үхэр хөллөсөн мухлагт тэрэгний дүрслэл Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уул, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын Бурхан толгойн 79-р булш, ОХУ-ын Буриадын Царамын 7-р булшнаас гарсан үйсэн эдлэл дээрх хөллөгөөнд ороогүй мухлагт тэрэгний дүрслэлүүдтэй тун ижил болно.

Бид багахан баримтанд тулгуурлан эртний хүмүүсийн ахуй амьдралд өргөн хэрэглэгддэг байсан тэрэг нь хойт насны ойлголтонд ч бас тодорхой байр суурьтай байсан болов уу хэмээх урьдчилсан дүгнэлтийг энэхүү өгүүлэлдээ хийж байна. Хадны зурагт дүрслэгдсэн бүх тэрэгний дугуйг хигээстэй дүрсэлсэн нь санамсаргүй зүйл биш бөгөөд өдөр тутмын ахуй амьдралдаа өргөн хэрэглэдэг тэрэг гэсэн утга илэрхийлж байгаа бол харин буган хөшөөн дээрх хигээсгүй тэрэг нь, магадгүй, талийгаачийн хойд насны ойлголттой холбоотой байж болох юм. Иймд хадны зурагт болон буган хөшөөнд сийлсэн тэрэгний дүрслэл, тэдгээрийн дугуйг хигээстэй эсвэл хигээсгүй дүрсэлсэн хэлбэр, зохиомжийг цаашид анхааран судлах асуудлын нэг гэж бодож байна.

НОМ ЗҮЙ

- Анхсанаа Г.*, 2017. Цагаан усны голын хадны зураг. *Studia Archaeologica*. Tom. (XXXVI), Fasc.1-26. УБ., т. 81-98.
- Батболд Н.*, 2014. Монголын говийн бүсийн хадны зургийн судалгаа. УБ.
- Баттулга Ц.*, 1998. Дэл уулын Баруун билүүний II, III бичээс. *Studia Archaeologica*. Tom. XVIII, Fasc. 9, УБ. т. 109-115.
- Баярсайхан Ж.*, 2016. Умард Монголын буган хөшөөд. Түүхийн ухааны докторын зэрэг горилсон зохиол. УБ. т. 223.
- Волков В.В.*, 1972. Древние колесницы Монгольского Алтая. *Studia Archaeologica*, Tom. V, Fasc. 6, УБ. с. 75-89, рис. 5,6.
- Волков В.В.*, 2002. Оленние камни монголии. М.
- Даваацэрэн Д.*, 2013. Таван толгойн баруун булангийн хадны зураг. Нүүдэлчдийн өв судлал. Tom. XV, Fasc. 5. УБ. т.36-42.
- Дорж Д.*, 1969. Хадны нэгэн зургийн тухай дахин өгүүлэх нь. *Studia Historica*. Tom. VIII, Fasc. 3. УБ.
- Доржсүрэн Ц.*, 1961. Говь-Алтайн Цагаан голын хадны зураг. *Studia Archaeologica*. Tom. II, Fasc. 2. УБ. т. 16-26.
- Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж.*, 2007. Хүннүгийн үеийн сүйх тэрэг. Археологийн судлал. Tom (IV) XXIV, Fasc 1-25. УБ. т.258-279.
- Кожин П.М.*, 1968. Гобийская квадрига. Советская археология №3. 1968, стр. 35-42.
- Миняев С.С., Сахаровская Л.М.*, 2006. Элитный комплекс захоронений сюнну в пади Царам. Российская археология №1, М. с. 194-201.
- Мөнхбаяр Ч., Мөнхбаатар Б.*, 2010. Монголын баруун бүс нутгийн хадны зургийн судалгаа хийгээд Норжин хайрхан уулын хадны зарим зургийн тухай. Түүхийн товчоон. Tom. V, Fasc. 1-43. УБ. т. 218-248.
- Наваан Д.*, 1976. К вопросу о происхождении телег в Центральной Азии. Олон улсын Монголч эрдэмтний III их хурал. УБ. с. 211-215.
- Наваан Д.*, 1999. Хүннүгийн өв соёл. УБ.

Ч.ЭНХТӨР, Ц.МӨНХБАТ

- Новгородова Э.А.*, 1984. Мир петроглифов Монголии. М.
- Нямбат М., Одбаатар Ц.*, 2010. Зүүнхангай сумын нутгаас шинээр олдсон буган хөшөөд. Нүүдэлчдийн өв судлал. Том. X, Fasc. 1-26. УБ. т. 57-66.
- Окладников А.П.*, 1964. Олень золотые рога. М.
- Өмирбек Б.*, 2012. Хойд Хөлцөөтийн хадны зураг дахь тэрэгний дүр, дүрслэл, он цагийн хамаарал. *Studia Archaeologica*. Tom. XXXII, Fasc. 6. УБ. т. 91-105.
- Паламдорж Ш., Мягмарсамбуу Г.*, 2006. Монголын нууц товчоо. УБ. т. 135.
- Руденко С.И.*, 1962. Культура хуннов и Ноинулинские курганы. М-Л.
- Санжмятав Я.*, 1995. Монголын хадны зураг. УБ.
- Төрбат Ц.*, 2001. Хүннү булшнаас гарсан үйсэн дээрх тэрэгний зураг. УБИС-ийн ЭШБ. Т. III, Fasc. 2, УБ. т. 66-68.
- Цэвээндорж Д.*, 1999. Монголын эртний урлагийн түүх. УБ.
- Цэвээндорж Д., Кубарев В.Д., Якобсон Э.*, 2010. Шивээт хайрханы хадны зураг. УБ.
- Цэвээндорж Д.*, 2011. Дуурлиг нарсны Хүннү булш I. Монгол-Солонгосын хамтарсан археологийн судалгааны тайлан-5. ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Солонгосын үндэсний музей. УБ. т.58-91.
- Цэрэндагва Я., Цэвээндорж Д.*, 2016. Далан Түргэний хос толгойн хадны зураг. УБ.
- Эрдэнэбаатар Д., Идэрхангай Т., Мижиддорж Э., Оргилбаяр С., Батболд Н., Галбадрах Б., Маратхаан А.*, 2015. Балгасын тал дахь гол мод-2-ын хүннүгийн язгууртны булшны судалгаа. УБ. т. 94-112.
- Jacobson E., Kubarev V.D., Tseveendorj D.* 2001. Mongolie du Nord-Ouest: Tsagaan salaa, Baga Oigor. Repertoire des Petroglyphes Asie centrale. Fascicule No. 6.2 Vols. Paris: De Boccard.